

МОНГОЛ УЛС  
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ  
ТОГТООЛ

2008 оны 7 дугаар  
сарын 07-ны өдөр

Дугаар 191

Улаанбаатар хот

"Банк бус санхүүгийн байгууллагын үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тооцож, хяналт тавих журам"-ыг шинэчлэн батлах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.2, Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 13.4 дэх заалтыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. "Банк бус санхүүгийн байгууллагын үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тооцож, хяналт тавих журам"-ыг хавсралтаар баталсугай.

2. Банк бус санхүүгийн байгууллагын үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг 2008 оны 7 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн энэхүү журмын дагуу тооцож, мөрдөж ажиллах, холбогдох санхүүгийн тайланг улирал (cap) бүрийн дараа сарын 10-ны өдрийн дотор Хороонд ирүүлж байхыг Банк бус санхүүгийн байгууллагын ТУЗ-ийн дарга, гүйцэтгэх захирал нарт даалгасугай.

3. Энэхүү журам батлагдсантай холбогдуулан Хорооны 2006 оны 11 дүгээр сарын 13-ны өдрийн 56 дугаар тогтоолоор батлагдсан "Банк бус санхүүгийн үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлт тогтоох тухай журам"-ыг хүчингүй болсонд тооцсугай.

4. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Бичил санхүүгийн газар /Н.Оюунчимэг/-т, олон нийтэд мэдээлэхийг Тамгын газар /Н.Удаанжаргал/-т тус тус даалгасугай.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН

*/Санхүүгийн зохицуулах хорооны 2010 оны 9 дүгээр сарын 23-ны өдрийн 246, 2013 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 531 дугаар тогтоолоор орсон өөрчлөлтүүдийг тусгав/*

Санхүүгийн зохицуулах хорооны 2008 оны  
07 дугаар сарын 7-ны өдрийн 191 дүгээр  
тогтоолын хавсралт

БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ  
ЗОХИСТОЙ ХАРЬЦААНЫ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙГ ТООЦОЖ,  
ХЯНАЛТ ТАВИХ ЖУРАМ

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. Монгол Улсын Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийнд заасан шаардлагыг банк бус санхүүгийн байгууллага (цаашид ББСБ гэх) хэрхэн биелүүлж байгааг тооцох зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг Хорооноос тогтоож, түүний биелэлтэд хяналт тавихад, холбогдох хуульд заасан хариуцлага хүлээлгэхэд энэхүү журмын зорилго оршино.

1.2. Энэхүү журамд хэрэглэгдсэн нэр томъёог дараах утгаар ойлгоно. Үүнд:

1.2.1. “Банк бус санхүүгийн байгууллагын өөрийн хөрөнгө” гэдэгт нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө, хоёрдугаар зэрэглэлийн өөрийн хөрөнгийг;

ББСБ-ын үйл ажиллагааны алдагдлыг хувь нийлүүлэгч нарт хүлээх хариуцлагатай нь уялдуулан хуваарилах үүднээс:

“Нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө” гэдэгт хувьцаат капитал дахь энгийн хувьцаа болон халаасны хувьцаа, нэмж төлөгдсөн капитал (ердийн хувьцаа), цэвэр ашгаас байгуулсан нөөцийн сан, хуримтлагдсан ашиг, алдагдал, хандивын капитал зэргийг;

*/Энэ заалтад Санхүүгийн зохицуулах хорооны 2013 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 531 дүгээр тогтоолоор өөрчлөлт орсон./*

“Хоёрдугаар зэрэглэлийн өөрийн хөрөнгө” гэдэгт хувьцаат капитал дахь давуу эрхтэй хувьцаа, нэмж төлөгдсөн капитал (давуу эрхтэй хувьцаа), дахин үнэлгээний нэмэгдэл, нийгмийн хөгжлийн сан, хоёрдогч өглөг зэргийг;

*/Энэ заалтад Санхүүгийн зохицуулах хорооны 2013 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 531 дүгээр тогтоолоор өөрчлөлт орсон./*

1.2.2. “Өөрийн хөрөнгийн хүрэлцээ” гэдэгт ББСБ нь санхүүгийн болон үйл ажиллагааны зарим нэг эрсдэлээс гарах алдагдлыг хаахад хүрэлцэхүйц хэмжээний өөрийн хөрөнгөтэй байгаа эсэхийг тодорхойлсон үнэлгээг;

1.2.3. “Хоёрдогч өглөг” гэдэгт хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрийг үндэслэн хувьцаагаар солих бөгөөд энэ талаар холбогдох гэрээнд тодорхой заасан байх өрийг бичгийг хэлнэ;

*/Энэ заалтыг Санхүүгийн зохицуулах хорооны 2013 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 531 дүгээр тогтоолоор өөрчлөн найруулсан./*

1.2.4. “Төлбөр түргэн гүйцэтгэх чадвар” (цаашид “ТТГЧ” гэх) гэдэгт бусдаас татан төвлөрүүлсэн хөрөнгийг харилцагчийн анхны шаардлагаар буцаан олгох чадварыг;

1.2.5. “Гадаад валютын ханийн эрсдэл” гэдэгт төгрөгийн гадаад валюттай харьцах ханш хэлбэлзэхэд алдагдал хүлээх эрсдэлийг;

*/Энэ заалтыг Санхүүгийн зохицуулах хорооны 2013 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 531 дүгээр тогтооолоор өөрчлөн найруулсан./*

1.2.6. “Гадаад валютын нээлттэй позиц” гэдэгт тэнцлийн гадаад валютын активын үлдэгдэл, тэнцлийн гадуур бүртгэлтэй байгаа гэрээ, хэлцлээр үүсч болзошгүй гадаад валютын авлагын нийлбэр болон тэнцлийн гадаад валютын пассивын үлдэгдэл, тэнцлийн гадуур бүртгэлтэй байгаа гэрээ, хэлцлээс үүсч болзошгүй гадаад валютын өглөгийн нийлбэрийн цэвэр зөрүүг;

1.2.7. “Гадаад валютын нээлттэй урт позиц” гэдэгт тэнцлийн гадаад валютын актив, тэнцлийн гадуур бүртгэлтэй байгаа гэрээ, хэлцлээс үүсч болзошгүй гадаад валютын авлагын нийлбэр нь тэнцлийн гадаад валютын пассив, тэнцлийн гадуур бүртгэлтэй байгаа гэрээ, хэлцлээс үүсч болзошгүй гадаад валютын өглөгийн нийлбэрээс давсан хэсгийг;

1.2.8. “Гадаад валютын нээлттэй богино позиц” гэдэгт тэнцлийн гадаад валютын пассив, тэнцлийн гадуур бүртгэлтэй байгаа гэрээ, хэлцлээс үүсч болзошгүй гадаад валютын өглөгийн нийлбэр нь тэнцлийн гадаад валютын актив, тэнцлийн гадуур бүртгэлтэй байгаа гэрээ, хэлцлээс үүсч болзошгүй гадаад валютын авлагын нийлбэрээс давсан хэсгийг;

1.2.9. “Гадаад валютын хаалттай позиц” гэдэгт тэнцлийн гадаад валютын актив, тэнцлийн гадуур бүртгэлтэй байгаа гэрээ, хэлцлээс үүсч болзошгүй гадаад валютын авлагын нийлбэр нь тэнцлийн гадаад валютын пассив, тэнцлийн гадуур бүртгэлтэй байгаа гэрээ, хэлцлээс үүсч болзошгүй гадаад валютын өглөгийн нийлбэртэй тэнцүү байхыг;

1.2.10. “Гадаад валютын нээлттэй позицийн лимит” гэдэгт тухайн нэг гадаад валют болон нийт гадаад валютын хувьд үссэн нээлттэй урт, богино позицийг ББСБ-ын өөрийн хөрөнгөд харьцуулан тогтоосон хязгаарлалтыг;

1.2.11. “Зах зээлийн эрсдэл” гэдэгт гадаад валютын ханш, хүү болон үнийн хэлбэлзлээс алдагдал хүлээх магадлалыг.

1.3. ББСБ үйл ажиллагаанд дараах зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдийг үнэн зөв тооцож, түүний өөрчлөлтөд нөлөөлсөн хүчин зүйл, шалтгааныг тогтоон үнэлэлт, дүгнэлт өгөх замаар учирч болзошгүй эрсдэлийг тооцох, түүнээс сэргийлэх арга хэмжээг авч ажиллана. Үүнд:

1.3.1. өөрийн хөрөнгийн хүрэлцээ;

1.3.2. төлбөр түргэн гүйцэтгэх чадвар;

1.3.3. актив хөрөнгийн төвлөрлийн эрсдэл;

1.3.4. гадаад валютын ханшийн эрсдэл;

1.3.5. итгэлцлийн үйлчилгээний өглөгийн эрсдэлийн;

1.3.6. үндсэн хөрөнгийн төвлөрөлийн;

1.4. ББСБ нь өөрийн үйл ажиллагааны бүх төрлийн эрсдэлийг үнэлэх, хяналт тавин удирдах зорилгоор дээр дурдагдсан зохистой харьцааны шалгуур үзүүлэлтээс гадна бусад журам, зааврыг холбогдох хууль, журамд нийцүүлэн боловсруулж, дотооддоо мөрдүүлж болно.

## ХОЁР. ӨӨРИЙН ХӨРӨНГИЙН ХҮРЭЛЦЭЭ

2.1. Энэхүү журмын 2.3-т заасны дагуу тохицуулсан өөрийн хөрөнгийг эрсдэлээр жигнэсэн нийт активт харьцуулж, ББСБ-ын өөрийн хөрөнгийн хүрэлцээг дараах зохистой харьцааг үндэслэн тодорхойлно. Үүнд:

2.1.1. өөрийн хөрөнгө, эрсдэлээр жигнэсэн нийт активын зохистой харьцаа нь 20 хувиас доошгүй байна. (цаашид "НӨХ" гэх);

2.1.2. нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө, эрсдэлээр жигнэсэн нийт активын зохистой харьцаа нь 10 хувиас доошгүй байна. (цаашид "НЗӨХ" гэх);

2.1.3. нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө, нийт активын зохистой харьцаа 10 хувиас доошгүй байна. (цаашид "НАХ" гэх);

2.2. Тухайн нэг ББСБ-ын эрсдэлийн ерөнхий түвшин нь ББСБ-ын нэгтгэлийн дундаж үзүүлэлтээс өндөр байвал Хорооны даргын шийдвэрээр ББСБ-ын өөрийн хөрөнгийн хүрэлцээний зохистой харьцааны үзүүлэлтийн байвал зохих доод хувь хэмжээг энэхүү журамд зааснаас дээгүүр тогтоож болно.

2.3. ББСБ-ын Өөрийн хөрөнгийн хүрэлцээний үзүүлэлтийг тооцоогоос өмнө өөрийн хөрөнгийн дүнг дараах байдлаар тохицуулсан байна. Үүнд:

2.3.1. урьдчилж төлсөн татварын дүнг нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгөөс хасч тооцох;

2.3.2. хоёрдугаар зэрэглэлийн өөрийн хөрөнгийн дүн нь нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгийн дүнгээс хэтрэхгүй байх, хэтэрсэн дүнг өөрийн хөрөнгийн дүнгээс хасч тооцох;

2.3.3. ББСБ банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхэлж буй компани нь татан буугдсан тохиолдолд хоёрдугаар зэрэглэлийн өөрийн хөрөнгөд хамрагдах хоёрдогч өглөгийг барагдуулах дараалал нь Иргэний хуулийн 32.5.6 дугаар зүйлд зааснаар зохицуулагдах;

2.3.4. урьдчилсан болон дараалсан хяналт, шалгалтаар илрүүлсэн зөрчил, дутагдалтай холбоотой залруулгын гүйлгээг зохих дансанд бүртгэж, өөрийн хөрөнгийг хорогдуулах буюу нэмэгдүүлэн бодит дүнг гаргах.

2.4. Эрсдэлээр жигнэсэн нийт активын дүнг тооцохдоо тэнцлийн активууд болон тэнцлийн гадуур бүртгэлтэй байгаа бусдын өмнө хүлээж болзошгүй үүргүүдийн дүнг энэхүү журмын нэгдүгээр хавсралтад заасан эрсдэлийн хувь хэмжээгээр жигнэж, тохируулна.

## ГУРАВ. ТӨЛБӨР ТҮРГЭН ГҮЙЦЭТГЭХ ЧАДВАР

3.1. Төлбөр түргэн гүйцэтгэх чадвар гэж бусдаас татан төвлөрүүлсэн хөрөнгийг тэдний анхны шаардлагаар буцаан олгох чадварыг илэрхийлэх ба төлбөр түргэн гүйцэтгэх чадварын зохистой харьцааны үзүүлэлтийг энэхүү журмын хоёрдугаар хавсралтын дагуу тооцож гаргана.

3.2. Түргэн борлогдох активыг тооцохдоо касс дахь бэлэн мөнгө, банк, санхүүгийн байгууллагад байршуулсан хадгаламж, харилцах дансны үлдэгдэл, арилжааны болон хөрөнгө оруулалтын үнэт цаас зэргийг энэхүү журмын хоёрдугаар хавсралтад заасан хувиар жигнэнэ.

3.3. Бусдаас татан төвлөрүүлсэн хөрөнгийг тооцохдоо банк, санхүүгийн байгууллага, төслийн санхүүжилтээр авсан зээл, зээлийн хүүгийн өглөг, итгэлцлийн, факторингийн болон мөнгөн гүйвуулга, цахим төлбөр тооцооны үйлчилгээгээр үүссэн өглөг, ББСБ-аас гаргасан хаалттай өрийн бичиг, бусад пассив дансны үлдэгдэл зэргийг энэхүү журмын хоёрдугаар хавсралтад заасан хувиар жигнэнэ.

3.4. ББСБ-ын бусдаас татан төвлөрүүлсэн хөрөнгийг төлөгдөх хугацаагаар нь дараах байдлаар ангилж ТТГЧ-ын үзүүлэлтэд оруулж тооцно. Үүнд:

3.4.1. урт хугацаатай буюу 1-ээс дээш жилийн хугацаатай хөрөнгийн дүнг 50 хувиар;

3.4.2. богино хугацаатай буюу 1 жил хүртэлх хугацаатай хөрөнгө, бусад пассивыг 100 хувиар.

3.5. Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын зохистой харьцааны үзүүлэлтийг тооцохдоо түргэн борлогдох активын дүнг бусдаас татан төвлөрүүлсэн хөрөнгийн дүнд харьцуулах замаар тооцох буюу төгрөг, гадаад валют болон тэдгээрийн нийлбэр дүнгээр нь тус тус тодорхойлох бөгөөд энэхүү зохистой харьцаа нь бусдаас татан төвлөрүүлсэн хөрөнгийн 8 хувиас доошгүй байна.

3.6. Зөвхөн өөрийн хөрөнгөөр үйл ажиллагаа явуулж буй ББСБ-ын хувьд уг үзүүлэлтийг тооцох шаардлагагүй буюу хангаж ажилласан гэж үзнэ.

## ДӨРӨВ. АКТИВ ХӨРӨНГИЙН ТӨВЛӨРЛИЙН ЭРСДЭЛ

4.1. Зээл болон түүнтэй адилтган тооцох бусад актив хөрөнгийн төвлөрлийн эрсдэлийг тооцох нь тухайн үйлчилгээг нэг болон цөөн этгээдэд хэт төвлөрүүлснээр хүү, төлбөрийг эргүүлэн төлүүлж чадахгүйд хүрэх, улмаар банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх компанийн ББСБ-ын санхүүгийн чадвар муудахаас урьдчилан сэргийлэх зорилготой.

4.2. Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуульд заасны дагуу нэг зээлдэгч болон холбогдох этгээдэд олгосон зээл, зээлтэй адилтган тооцох бусад актив хөрөнгө, төлбөрийн баталгааны нийлбэр дүн нь өөрийн хөрөнгийн 30 хувиас хэтрэхгүй ба ББСБ-аас 20 том

зээлдэгчид олгосон зээл, түүнтэй адилтган тооцох бусад актив хөрөнгийн тайланг энэхүү журмын гуравдугаар хавсралтын дагуу гаргана.

4.3. ББСБ-ын хувьцаа эзэмшигч, Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүд, гүйцэтгэх захирал, ажилтнууд тэдгээртэй холбогдох этгээд болон тэдний эзэмшлийн нэгжид олгох зээл, зээлтэй адилтган тооцох бусад актив хөрөнгө, төлбөрийн баталгааны дээд хэмжээ нь өөрийн хөрөнгийн 10 хувь, тэдгээрийн нийлбэр дүн нь өөрийн хөрөнгийн 25 хувиас тус тус хэтрэхгүй байна. Тайланг энэхүү журмын дөрөвдүгээр хавсралтын дагуу гаргана.

*/Энэ заалтад Санхүүгийн зохицуулах хорооны 2013 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 531 дүгээр тогтоолоор өөрчлөлт орсон./*

4.4. ББСБ нь зээл, үнэт цаас, хүлээж болзошгүй үүрэг, бусад активын эрсдэлийн санг Монголбанкны Ерөнхийлөгч, Сангийн сайдын хамтарсан 2010 оны 8 дугаар сарын 11-ний өдрийн 475/182 дугаар тушаалаар батлагдсан “Активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журам”-ын дагуу тооцож байгуулна. Тайланг энэхүү журмын тавдугаар хавсралтын дагуу тооцож гаргана.

*/Энэ хэсгийг Хорооны 2010 оны 9 дүгээр тогтоолоор өөрчлөн найруулсан/*

4.4<sup>1</sup> Чанаргүй зээлийн өрийн үлдэгдэл нь нийт зээлийн багцын 5 хувиас хэтрэхгүй байна.

*/Энэ хэсгийг Санхүүгийн зохицуулах хорооны 2013 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 531 дүгээр тогтоолоор нэмсэн/*

*/Энэ хэсгийг Санхүүгийн зохицуулах хорооны 2014 оны 2 дугаар сарын 26-ны өдрийн 57 дугаар тогтоолоор хассан/*

4.6. ББСБ-ын худалдан авах үнэт цаасны эзэмшлийн нийт дүн нь ББСБ-ын өөрийн хөрөнгийн 20 хувиас хэтрэхгүй, нэг компанийн гаргасан хувьцааны нийт дүнгийн 10 хувиас дээшгүй байна. Тайланг энэхүү журмын зургаадугаар хавсралтын дагуу гаргана.

4.7. ББСБ-ын гаргасан төлбөрийн баталгааны нийт дүн өөрийн хөрөнгийн 70 хувиас хэтрэхгүй. Тэнцлийн гадуур бүртгэлтэй хүлээж болзошгүй үүрэг, төлбөрийн баталгааны тайланг энэхүү журмын долоодугаар хавсралтын дагуу гаргана.

4.8 Зээл, түүнтэй адилтган тооцох бусад актив хөрөнгийн газарзүйн байршил, эдийн засгийн салбар, зориулалт, барьцаа хөрөнгө болон батлан даагч аж ахуйн нэгжтэй холбоотой төвлөрлийн эрсдэлийг зохих түвшинд нь барьж байх хязгаарлалтыг ББСБ өөрөө тогтоож, дотооддоо мөрдүүлнэ.

## ТАВ. ГАДААД ВАЛЮТЫН ХАНШИЙН ЭРСДЭЛ

5.1. Гадаад валютын эрсдэлийн үзүүлэлтийг тооцох нь валютын ханшийн өөрчлөлт, ханшийн тэгшитгэлээс хүлээж болох алдагдал ББСБ-ын санхүүгийн чадварт хэрхэн нөлөөлөх, гадаад актив, пассивыг зохистой байршуулаагүйгээс үүсч болох эрсдэлээс хамгаалах зорилготой.

5.2. Тэнцлийн болон тэнцлийн гадуурх дансанд бүртгэлтэй нийт гадаад валютын актив, пассивын зөрүүг өөрийн хөрөнгөд харьцуулан гадаад валютын эрсдэлийг тооцно. Гадаад актив, пассивын зөрүү нь нэгж болон нийт валютын хувьд өөрийн хөрөнгийн +/- 40 хувиас хэтрэхгүй байна. ББСБ нь гадаад валютын зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тухайн нэгж валютын хувьд дээрх хязгаарлалтын хүрээнд тогтоож болно.

5.3. Гадаад валютын ханшийн эрсдэлийн тайланг энэхүү журмын наймдугаар хавсралтын дагуу тооцож гаргана.

5.4. Гадаад активт банк, санхүүгийн байгууллага дахь гадаад валютын харилцах, хадгаламж, касс дахь бэлэн валют, гадаад валютаар илэрхийлэгдсэн зээл, түүнтэй адилтган тооцох активын үлдэгдэл болон бусад актив багтана. Гадаад пассивт гадаад валютаар илэрхийлэгдсэн итгэлцлийн үйлчилгээний өглөг, бусдаас авсан зээл, төслийн зээл, гаргасан өрийн бичиг, бусад өглөгүүд, тэнцлийн гадуурх дансны үлдэгдэлд гадаад валютаар гаргасан бүх төрлийн төлбөрийн баталгаанууд хамаарна.

5.5 Гадаад валютаар бусдаас санхүүгийн эх үүсвэр татан төвлөрүүлээгүй, гадаад валютаар илэрхийлэгдэх актив хөрөнгөгүй ББСБ-ын хувьд энэ үзүүлэлтийг тооцох шаардлагагүй буюу хангаж ажилласан гэж үзнэ.

### ЗУРГАА. ИТГЭЛЦЛИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ӨГЛӨГ

6.1. Итгэлцлийн үйлчилгээний өглөг нь тодорхой хугацааны дараа эргэн төлөгдөх нөхцөлтэй эх үүсвэр тул тус үйлчилгээний эрсдэлийг бууруулах зорилгоор итгэлцлийн үйлчилгээний зохистой харьцааг тооцно.

6.2. Итгэлцлийн үйлчилгээний зохистой харьцааны үзүүлэлтийг тооцоходоо итгэлцлийн өглөгийг өөрийн хөрөнгөд харьцуулах замаар тооцох бөгөөд энэхүү харьцаа нь 80 хувиас ихгүй байна. Итгэлцлийн үйлчилгээний өглөг, өөрийн хөрөнгийн зохистой харьцааны тайланг энэхүү журмын есдүгээр хавсралтын дагуу гаргана.

*/Энэ хэсэгт Санхүүгийн зохицуулах хорооны 2012 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн 346 дүгээр тогтоолоор өөрчлөлт орсон/*

6.3. Итгэлцлийн үйлчилгээний төвлөрлийн судалгааны тайланг энэхүү журмын аравдугаар хавсралтын дагуу гаргана.

### ДОЛОО. ҮНДСЭН ХӨРӨНГИЙН ҮЗҮҮЛЭЛТ

7.1. ББСБ-ын Бусдаас татан төвлөрүүлсэн хөрөнгийг үндсэн үйл ажиллагаа буюу хуульд заасан үйл ажиллагааг дэмжих зорилгоор ББСБ-ын үндсэн хөрөнгийн үзүүлэлтийн хязгаарлалтыг тогтооно.

7.2. ББСБ-ын цэвэршүүлсэн үндсэн хөрөнгийн дүнг нийт активт харьцуулж үндсэн хөрөнгийн үзүүлэлтийг тооцно. Үндсэн хөрөнгийн харьцаа нь 15 хувиас дээшгүй байна. Үндсэн хөрөнгө, нийт активын зохистой харьцааны тайланг энэхүү журмын арваннэгдүгээр хавсралтын дагуу гаргана.

**НАЙМ. ЦАХИМ ТӨЛБӨР ТООЦОО, МӨНГӨН ГҮЙВУУЛГЫН  
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ҮЗҮҮЛЭЛТ, ХААЛТТАЙ ӨРИЙН БИЧГИЙН ҮЗҮҮЛЭЛТ**

*/Энэ зүйлд Санхүүгийн зохицуулах хорооны 2013 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 531 дүгээр тогтоолоор өөрчилсөн./*

8.1. ББСБ-ын Цахим төлбөр тооцоо, мөнгөн гүйвуулгын үйлчилгээний эрсдэлийг тооцох, үйлчлүүлэгчдийг учирч болзошгүй эрсдэлээс хамгаалах зорилгоор цахим төлбөр тооцоо, мөнгөн гүйвуулгын тайланг арванхоёрдугаар хавсралтын дагуу гаргана.

8.2 ББСБ нь хаалттай өрийн бичгийн зохистой харьцааны үзүүлэлтийг тооцоходоо гаргасан хаалттай өрийн бичгийг өөрийн хөрөнгөд харьцуулах замаар тооцох бөгөөд энэхүү харьцаа нь 50 хувиас ихгүй байна. Хаалттай өрийн бичгийн тайланг энэхүү журмын арвангуравдугаар хавсралтын дагуу гаргана.

*/Энэ хэсгийг Санхүүгийн зохицуулах хорооны 2013 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 531 дүгээр тогтоолоор нэмсэн./*

**ЕС НЭГ. ХЯНАЛТ, ХАРИУЦЛАГА**

9.1. ББСБ-ын үйл ажиллагаанд мөрдөгдөх зохистой харьцааны шалгуур үзүүлэлтуудийн биелэлтэд Хороо сар, улирал тутам хяналт тавьж, шаардлагатай гэж үзвэл газар дээр нь шалгалт хийж, холбогдох арга хэмжээг авна.

9.2. Аль нэг зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг 2 улирал дараалан хангаагүй ББСБ-д Хорооноос баталсан "Банк бус санхүүгийн үйл ажиллагааны зохицуулалтын журам"-д заасан арга хэмжээг авна.

9.3. ББСБ-ын өөрийн хөрөнгийн хүрэлцээг дараах байдлаар ангилна. Үүнд:

9.3.1. НӨХ харьцаа нь 20 буюу түүнээс дээш хувь, НЗӨХ, НАХ харьцаа нь 10 буюу түүнээс дээш хувь байгаа ББСБ-ыг зохистой хэмжээний өөрийн хөрөнгөтэй,

9.3.2. НӨХ харьцаа нь 11-19 хүртэл хувь, НЗӨХ, НАХ харьцаа нь 5-9 хүртэл хувь байгаа ББСБ-ийн өөрийн хөрөнгө нь дутагдалтай,

9.3.3. НӨХ харьцаа нь 0-10 хүртэл хувь, НЗӨХ харьцаа, НАХ харьцаа нь 0-4 хүртэл хувь байгаа ББСБ-ыг өөрийн хөрөнгийн хэмжээ алдагдаж байгаа,

9.3.4. НӨХ нь 0 хувиас бага байгаа ББСБ-ыг өөрийн хөрөнгийн хэмжээ алдагдсан.

9.4. Энэхүү журмын 9.3.2-т заасан ангилалд хамрагдсан ББСБ-д дараах арга хэмжээг авна. Үүнд:

9.4.1. албан бичгээр анхааруулах;

9.4.2. зөрчлийг арилгах талаар хугацаатай үүрэг, даалгавар өгөх;

9.4.3. хувь нийлүүлсэн хөрөнгийг нэмэгдүүлэхийг шаардах;

*/Энэ заалтад Санхүүгийн зохицуулах хорооны 2013 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 531 дүгээр тогтоолоор өөрчлөлт орсон./*

9.4.4. нэгж шинээр байгуулах, нэмэлт үйл ажиллагаа эрхлэхийг хориглох.

9.5. Энэхүү журмын 9.3.3-т заасан ангилалд хамрагдсан ББСБ-д дараах арга хэмжээг авна. Үүнд:

9.5.1. алдагдал учруулж буй зарим үйл ажиллагааг түр буюу бүрэн зогсоох;

9.5.2. ногдол ашиг хуваарилахыг түдгэлзүүлэх;

9.5.3. бусдаас эх үүсвэр татан төвлөрүүлэхийг хориглох.

9.6. Энэхүү журмын 9.3.4-т заасан ангилалд анх удаа хамрагдсан байдлыг үл харгалзан ББСБ-ын банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг б сар хүртэл хугацаагаар түдгэлзүүлэх арга хэмжээ авна.

9.7. Тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн хугацаанд Хорооны улсын байцаагчаас өгөгдсөн үүрэг даалгавар, шаардлагыг биелүүлж ажиллаагүй ББСБ-ын банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгож, нийтэд мэдээлнэ.

9.8. Хорооноос дээрх арга хэмжээнүүдийг хүлээлгэхдээ адил зөрчилд адил арга хэмжээ авах зарчмыг баримтална.

9.9. ББСБ нь Хорооны шийдвэрийг үндэслэлгүй гэж үзвэл Хорооны Хяналтын зөвлөлд гомдол гаргаж болно. Албадлагын арга хэмжээ ногдуулсан нь бусад хууль тогтоомжийн дагуу хүлээлгэх хариуцлагаас ББСБ-ыг чөлөөлөх үндэслэл болохгүй.

## АРАВ. БУСАД

10.1. ББСБ нь зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдийг энэхүү журмын хавсралтуудын дагуу сар, улирал бүр тооцож, тайланг сар, улирал бүрийн дараа сарын 10-ны өдрийн дотор Хороонд ирүүлнэ. Үүнд:

10.1.1. Өөрийн хөрөнгө, нийт эрсдэлээр жигнэсэн активын зохистой харьцааны тайлан (Хавсралт 1);

10.1.2. Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын тайлан (Хавсралт 2);

10.1.3. ББСБ-ын 20 том зээлдэгчид олгосон зээл, зээлтэй адилтган тооцох бусад актив хөрөнгийн тайлан (Хавсралт 3);

10.1.4. ББСБ-ын хувьцаа эзэмшигч, өөрийн ажилтан, холбогдох этгээдэд олгосон зээл, зээлтэй адилтган тооцох бусад актив хөрөнгийн тайлан (Хавсралт 4);

*/Энэ заалтад Санхүүгийн зохицуулах хорооны 2013 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 531 дүгээр тогтоолоор өөрчлөлт орсон./*

10.1.5. Активын эрсдэлийн сангийн хүрэлцээний үзүүлэлтийн тайлан (Хавсралт 5);

10.1.6. Үнэт цаасны төвлөрлийн тайлан (Хавсралт 6);

10.1.7. ББСБ-ын тэнцлийн гадуур бүртгэлтэй хүлээж болзошгүй үүрэг, төлбөрийн баталгааны судалгааны тайлан (Хавсралт 7);

10.1.8. Гадаад валютын ханшийн эрсдэлийн тайлан (Хавсралт 8);

10.1.9. Итгэлцлийн үйлчилгээний өглөг, өөрийн хөрөнгийн зохистой харьцааны тайлан (Хавсралт 9);

*/Энэ хэсэгт Санхүүгийн зохицуулах хорооны 2012 оны 11 дүгээр тайлан 28-ны өдрийн 346 дүгээр тогтоолоор өөрчлөлт орсон/*

10.1.10. итгэлцлийн үйлчилгээний төвлөрлийн тайлан (Хавсралт 10);

10.1.11. үндсэн хөрөнгө, нийт активын зохистой харьцааны тайлан (Хавсралт 11);

10.1.12. цахим төлбөр тооцоо, мөнгөн гүйвуулгын тайлан (Хавсралт 12);

10.1.13. хаалттай өрийн бичиг, өөрийн хөрөнгийн зохистой харьцааны тайлан (Хавсралт 13)

*/Энэ заалтыг Санхүүгийн зохицуулах хорооны 2013 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 531 дүгээр тогтоолоор нэмсэн/*

10.1.14. долоо хоног тутмын гадаад валютын арилжааны тухай мэдээ /Хавсралт 14/;

*/Энэ заалтыг Санхүүгийн зохицуулах хорооны 2013 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 531 дүгээр тогтоолоор нэмсэн/*

10.1.15. сар тутмын валют арилжааны тухай мэдээ /Хавсралт 15/;

*/Энэ заалтыг Санхүүгийн зохицуулах хорооны 2013 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 531 дүгээр тогтоолоор нэмсэн/*

10.2. Банк бус санхүүгийн итгэлцлийн, цахим төлбөр тооцоо, мөнгөн гүйвуулгын болон төлбөр тооцооны хэрэгсэл гаргах үйлчилгээний үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй ББСБ дээрх тайлангууд болон тухайн ажил үйлчилгээний талаарх мэдээг сар бүрийн 10-ны өдрийн дотор Хороонд ирүүлнэ.

10.2<sup>1</sup> Активын өгөөжийг тооцоходоо татварын өмнөх цэвэр ашгийг нийт активын дундажтай харьцуулан тооцно.

*/Энэ хэсгийг Санхүүгийн зохицуулах хорооны 2013 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 531 дүгээр тогтоолоор нэмсэн/*

10.2<sup>2</sup> Өөрийн хөрөнгийн өгөөжийг тооцохдоо татварын өмнөх цэвэр ашгийг өөрийн хөрөнгийн дундажтай харьцуулан тооцно.

*/Энэ хэсгийг Санхүүгийн зохицуулах хорооны 2013 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 531 дүгээр тогтоолоор нэмсэн/*

10.2<sup>3</sup> Долоо хоног тутмын гадаад валютын арилжааны тухай мэдээг энэхүү журмын 14 дүгээр хавсралтын дагуу гаргаж дараа долоо хоногийн эхний хагаст Монголбанкинд, сар тутмын валют арилжааны тухай мэдээг энэхүү журмын 15 дугаар хавсралтын дагуу гаргаж, дараа сарын 10-ны дотор Хороонд ирүүлнэ.

*/Энэ хэсгийг Санхүүгийн зохицуулах хорооны 2013 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 531 дүгээр тогтоолоор нэмсэн/*

10.4. Монгол улсын Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийг зөрчсөн нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол гэм буруутай этгээдэд Хорооны улсын байцаагч эрх хэмжээнийхээ хүрээнд тус хуулийн 20 дугаар зүйлийн 1 дэх заалтын дагуу захиргааны хариуцлага ногдуулна.

## САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО

"Банк бус санхүүгийн байгууллагын үйл ажиллагааны зохицой харьцааны шалгуур үзүүлэлтийг тооцож, хяналт тавих журам"-ын хавсралт 1

**ӨӨРИЙН ХӨРӨНГӨ, НИЙТ ЭРСДЭЛЭЭР ЖИГНЭСЭН АКТИВЫН  
ЗОХИСТОЙ ХАРЬЦААНЫ ТАЙЛАН**

ББСБ-ЫН НЭР

БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГА

20 оны ...-р улирал

/мянган  
төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТҮҮД		НИЙТ ДҮН		
A	ӨӨРИЙН ХӨРӨНГӨ /AI+AI/			
I	1-р зэрэглэлийн өөрийн хөрөнгө /1+2+3+4+5-7-8+(+/-9)/			
1	Ердийн хувьцаа			
2	Халаасны хувьцаа			
3	Нэмж төлөгдсөн капитал /Ердийн хувьцаа/			
4	Хандивын капитал			
5	Нөөцийн сан			
6	Тухайн жилийн ашиг			
7	Өнгөрсөн жилийн ашиг			
8	Тухайн жилийн алдагдал			
9	Өнгөрсөн жилийн алдагдал			
	Дүн			
10	Тохируулга*			
	Дүн /тохируулга/			
II 2-р зэрэглэлийн өөрийн хөрөнгө /11+12+13+14/				
11	Давуу эрхтэй хувьцаа			
12	Дахин үнэлгээний нэмэгдэл			
13	Нийгмийн хөгжлийн сан			
14	Хоёрдогч өглөг			
B	ЭРСДЛЭЭР ЖИГНЭСЭН АКТИВЫН ДҮН /БI+БII+A10/	***		
		Эрсдэлийн түвшин	Ня-бо тайлан тэнцлийн нийт актив	Эрсдэлээр жигнэсэн
I	Активын дүн /1+2+3+4+5+6+7+8+9+10/			
1	Бэлэн хөрөнгө	0%		
2	Банк, санхүүгийн байгуулага дахь харилцах, хадгаламж	0%		
3	Хөрөнгө оруулалтын үнэт цаас /цэврээр/	30%		
4	Арилжааны үнэт цаас /цэврээр/	30%		
5	Зээлийн өрийн үлдэгдэл /цэврээр/	100%		
6	Санхүүгийн түрээсийн авлага /цэврээр/	100%		
7	Факторингийн тооцооны авлага /цэврээр/	100%		
8	Өмчлөх бусад үндсэн хөрөнгө /цэврээр/	100%		

9	Үндсэн ба биет бус хөрөнгө /цэврээр/	100%		
10	Бусад актив /цэврээр/	100%		
<i>II Тэнцлийн гадуурх дансны дүн</i>				
12	Хүлээж болзошгүй үүргүүд /төлбөрийн баталгаа, зээлийн шугам/	100%		
В	НЭГДҮГЭЭР ЗЭРЭГЛЭЛИЙН ӨӨРИЙН ХӨРӨНГӨ, ЭРСДЛЭЭР ЖИГНЭСЭН НИЙТ АКТИВЫН ХАРЬЦАА (А1/Б*100%)		****	
Г	БАЙВАЛ ЗОХИХ /10 ХУВИАС ДООШГҮЙ/		****	10.00%
Д	ХАРЬЦААНЫ БИЕЛЭГДЭЭГҮЙ ХУВЬ /Г-В/		****	
Е	ШААРДЛАГАТАЙ НЭМЭЛТ И ЗЭРЭГЛЭЛИЙН ӨӨРИЙН ХӨРӨНГӨ (Б*0,1-А1)		****	
Ж	ӨӨРИЙН ХӨРӨНГӨ, ЭРСДЭЛЭЭР ЖИГНЭСЭН НИЙТ АКТИВЫН ХАРЬЦАА (А/Б*100%)		****	
З	БАЙВАЛ ЗОХИХ /20 ХУВИАС ДООШГҮЙ/		****	20.00%
И	ХАРЬЦААНЫ БИЕЛЭГДЭЭГҮЙ ХУВЬ /З-Ж/		****	
К	ШААРДЛАГАТАЙ НЭМЭЛТ ӨӨРИЙН ХӨРӨНГӨ (Б*0,2-А)		****	
Л	НЭГДҮГЭЭР ЗЭРЭГЛЭЛИЙН ӨӨРИЙН ХӨРӨНГӨ, НИЙТ АКТИВЫН ХАРЬЦАА (А1/Б*100%)		****	
М	БАЙВАЛ ЗОХИХ /10 ХУВИАС ДООШГҮЙ/		****	10.00%
Н	ХАРЬЦААНЫ БИЕЛЭГДЭЭГҮЙ ХУВЬ /М-Л/		****	
О	ШААРДЛАГАТАЙ НЭМЭЛТ ӨӨРИЙН ХӨРӨНГӨ (А1/Б1*0,1)		****	

ТАЙЛАНГ ҮНЭН ЗӨВ ГАРГАСАН:

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

НЭР

ЕРӨНХИЙ НЯ-БО

НЭР

ЭДИЙН ЗАСАГЧ

НЭР

"Банк бус санхүүгийн байгууллагын үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тооцож, хяналт тавих журам"-ын хавсралт 2

## ТӨЛБӨР ТҮРГЭН ГҮЙЦЭТГЭХ ЧАДВАРЫН ТАЙЛАН

ББСБ-ЫН НЭР

БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГА

20 оны ...-р улирал

/мянган төгрөгөөр/

	ҮЗҮҮЛЭЛТҮҮД	Жигнэх хувь	төгрөг	гадаад валют	бүгд
<b>A</b>	<b>ТҮРГЭН БОРЛОГДОХ АКТИВ /A1+A2+A3+A4/</b>				
1	Бэлэн мөнгө	100%			
2	Банк, санхүү байгуулага дахь харилцах, хадгаламж	100%			
3	Хөрөнгө оруулалтын үнэт цаас	70%			
4	Арилжааны үнэт цаас	70%			
<b>B</b>	<b>БУСДААС ТАТАН ТӨВЛӨРҮҮЛСЭН ХӨРӨНГӨ /Б1+Б2+Б3+Б4+Б5+Б6+Б7/</b>				
1	Итгэлцлийн үйлчилгээний өглөг	75%			
2	Банк, банк бус санхүүгийн байгууллагаас авсан зээл /1-ээс дээш жилийн хугацаатай/	50%			
3	Банк, банк бус санхүүгийн байгууллагаас авсан зээл /1 жил хүртэлх хугацаатай/	100%			
4	Төслийн зээлийн санхүүжилт /1-ээс дээш жилийн хугацаатай/	50%			
5	Төслийн зээлийн санхүүжилт /1 жил хүртэлх хугацаатай/	100%			
6	Хаалттай өрийн бичиг	100%			
7	Бусад эх үүсвэр	80%			
8	Бусад пассив	0%			
<b>В</b>	<b>ТӨЛБӨР ТҮРГЭН ГҮЙЦЭТГЭХ ЧАДВАРЫН ХАРЬЦАА (А/Б*100%)</b>				
<b>Г</b>	<b>ЗОХИСТОЙ ХАРЬЦАА /8 ХУВИАС ДООШГҮЙ/</b>		8.00%	8.00%	8.00%
<b>Д</b>	<b>ХАРЬЦААНЫ БИЕЛЭГДЭЭГҮЙ ХУВЬ /Г-В/</b>				
<b>Е</b>	<b>ШААРДЛАГАТАЙ НЭМЭЛТ ТҮРГЭН БОРЛОГДОХ АКТИВ (Б*0,08-А)</b>				

ТАЙЛАНГ ҮНЭН ЗӨВ ГАРГАСАН:

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ  
ЕРӨНХИЙ НЯ-БО  
ЭДИЙН ЗАСАГЧ

НЭР  
НЭР  
НЭР

"Банк бус санхүүгийн байгууллагын үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тооцож, хяналт тавих журам"-ын хавсралт 3

**ББСБ-ЫН 20 ТОМ ЗЭЭЛДЭГЧИД ОЛГОСОН ЗЭЭЛ, ЗЭЭЛТЭЙ АДИЛТГАН ТООЦОХ БУСАД АКТИВ /САНХҮҮГИЙН ТҮРЭЭС, ФАКТОРИНГ/ ХӨРӨНГИЙН ТАЙЛАН**

**ББСБ-ЫН НЭР**

*20 оны ...-р улирал*

**БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГА**

*/мянган төгрөгөөр/*

Дд	Зээлдэгчийн нэр*	Зээл, зээлтэй адилтган тооцох бусад актив хөрөнгийн эхний үлдэгдэл	Зориулалт	Олгосон огноо	Төлөгдөх хугацаа	Хугацаа сунгасан төлөгдөх огноо	Барьцаа хөрөнгийн үнэлгээ	Зээл, зээлтэй адилтган тооцох бусад актив хөрөнгийн тайлант үеийн үлдэгдэл	Активын ангилаал	Өөрийн хөрөнгөд эзлэх хувь
1										
2										
3										
4										
5										
6										
7										
8										
9										
10										
11										
12										
13										
14										
15										
16										
17										
18										
19										
20	БҮГД									

Хамгийн том зээлдэгч

ТАЙЛАНГ ҮНЭН ЗӨВ ГАРГАСАН:

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ  
ЕРӨНХИЙ НЯ-БО  
ЭДИЙН ЗАСАГЧ

НЭР  
НЭР  
НЭР

"Банк бус санхүүгийн байгууллагын үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тооцож, хяналт тавих журам"-ын хавсралт 4

**ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧ, ӨӨРИЙН АЖИЛТАН, ХОЛБОГДОХ ЭТГЭЭДЭД ОЛГОСОН ЗЭЭЛ, ЗЭЭЛТЭЙ АДИЛТГАН ТООЦОХ БУСАД АКТИВ /САНХҮҮГИЙН ТҮРЭЭС, ФАКТОРИНГ/ ХӨРӨНГИЙН ТАЙЛАН**

**ББСБ-ЫН НЭР**

**БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГА**

*20 оны ...-р улирал*

*/мянган төгрөгөөр/*

Дд	Зээлдэгчийн нэр	Зээл, зээлтэй адилтган тооцох бусад актив хөрөнгийн эхний үлдэгдэл	Зориулалт	Зээлдэгчийн хамаарал*	Олгосон огноо	Төлөгдөх хугацаа	Хугацаа сунгасан төлөгдөх огноо	Барьцаа хөрөнгийн үнэлгээ	Зээл, зээлтэй адилтган тооцох бусад актив хөрөнгийн тайлант үеийн Үлдэгдэл	Активын ангилал	Өөрийн хөрөнгөд эзлэх хувь
1											
2											
3											
4											
5											
6											
7											
8											
9											
10											
11											
12											
13											
14											
15											
16											
17											

18									
19									
20									
	БҮГД	-				-	-		

Хамгийн том зээлдэгч

Тайлбар: ББСБ-ын хувьцаа эзэмшигч бол 1, ТУЗ-ийн гишүүн бол 2, гүйцэтгэх захирал бол 3, ажилтан бол 4, тэдгээрийн холбогдох этгээд бол 5 гэсэн тоог бичнэ.

ТАЙЛАНГ ҮНЭН ЗӨВ ГАРГАСАН:

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ  
ЕРӨНХИЙ НЯ-БО  
ЭДИЙН ЗАСАГЧ

НЭР  
НЭР  
НЭР

"Банк бус санхүүгийн байгууллагын үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тооцож, хяналт тавих журам"-ын хавсралт 5

## АКТИВЫН ЭРСДЭЛИЙН САНГИЙН ХҮРЭЛЦЭЭ, ХАНГАМЖИЙН СУДАЛГААНЫ ТАЙЛАН

ББСБ-ЫН НЭР

БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГА

*20 оны ...-р улирал*

*/мянган  
төгрөгөөр/*

	Актив	Үлдэгдэл	Эрсдэлийн сан байгуулах хувь	Байгуулбал зохих сан	Байгуулсан сан	Илүү (+) дутуу (-)
1	Хэвийн зээл	0.00	0%	0.00		
2	Хугацаа хэтэрсэн зээл	0.00	5%	0.00		
3	Чанаргүй зээл. Үүнээс: а/ Хэвийн бус б/ Эргэлзээтэй в/ Myu	0.00 0.00 0.00 0.00	25% 50% 100%	0.00 0.00 0.00		
4	Хэвийн санхүүгийн түрээс	0.00	0%	0.00		
5	Хугацаа хэтэрсэн санхүүгийн түрээс	0.00	5%	0.00		
6	Чанаргүй санхүүгийн түрээс. Үүнээс: а/ Хэвийн бус б/ Эргэлзээтэй в/ Myu	0.00 0.00 0.00 0.00	25% 50% 100%	0.00 0.00 0.00		
7	Хэвийн факторинг	0.00	0%	0.00		
8	Хугацаа хэтэрсэн факторинг	0.00	5%	0.00		
9	Чанаргүй факторинг. Үүнээс: а/ Хэвийн бус б/ Эргэлзээтэй в/ Myu	0.00 0.00 0.00 0.00	25% 50% 100%	0.00 0.00 0.00		
10	Хэвийн авлага	0.00	0%	0.00		
11	Хугацаа хэтэрсэн авлага	0.00	5%	0.00		
12	Чанаргүй авлага. Үүнээс: а/ Хэвийн бус б/ Эргэлзээтэй в/ Myu	0.00 0.00 0.00 0.00	25% 50% 100%	0.00 0.00 0.00		
13	Үнэт цаас	0.00	0%	0.00		
14	Хэвийн ӨБҮХХ	0.00	0%	0.00		
15	Хугацаа ӨБҮХХ	0.00	5%	0.00		
16	Чанаргүй ӨБҮХХ. Үүнээс: а/ Хэвийн бус б/ Эргэлзээтэй в/ Myu	0.00 0.00 0.00 0.00	25% 50% 100%	0.00 0.00 0.00		
17	Хүлээж болзошгүй үүргүүд /төлбөрийн баталгаа/	0.00	0%	0.00		
	НИЙТ	0.00		0.00		

ТАЙЛАНГ ҮНЭН ЗӨВ ГАРГАСАН:

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ	НЭР
ЕРӨНХИЙ НЯ-БО	НЭР
ЭДИЙН ЗАСАГЧ	НЭР

"Банк бус санхүүгийн байгууллагын үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тооцож, хяналт тавих журам"-ын хавсралт 6

## ҮНЭТ ЦААСНЫ ТӨВЛӨРЛИЙН ТАЙЛАН

ББСБ-ЫН НЭР

БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГА

*20 оны ...-р улирал*

*/мянган төгрөгөөр/*

Д д	Үнэт цаасны нэр, төрөл	Худалдан авсан үнэт цаасны дүн	Худалда ж авсан огноо	Зарсан огноо	Үнэт цаасны тайлант үеийн үлдэгдэл	Өөрийн хөрөнгөд эзлэх хувь
1						
2						
3						
4						
5						
6						
7						
8						
9						
10						
11						
12						
13						
14						
15						
16						
17						
18						
19						
20						
	БҮГД					

ТАЙЛАНГ ҮНЭН ЗӨВ ГАРГАСАН:

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

НЭР

ЕРӨНХИЙ НЯ-БО

НЭР

ЭДИЙН ЗАСАГЧ

НЭР

"Банк бус санхүүгийн байгууллагын үйл ажиллагааны зохицой харьцааны шалгуур үзүүлэлтийг тооцож, хяналт тавих журам"-ын хавсралт 7

**ТЭНЦЛИЙН ГАДУУР БҮРТГЭЛТЭЙ ХҮЛЭЭЖ БОЛЗОШГҮЙ ҮҮРЭГ, ТӨЛБӨРИЙН БАТАЛГААНЫ СУДАЛГААНЫ ТАЙЛАН**

**ББСБ-ЫН НЭР**

**БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГА**

*20 оны ...-р улирал*

*/мянган төгрөгөөр/*

Д/Д	ДАНС	ААН-ийн нэр	Регистрийн дугаар	Улсын бүртгэлийн дугаар	Баталгааны зориулалт	ААН, байгууллагын захирлын	Нэр	Регистрийн дугаар	ББСБ-тай ямар холбоотой эсэх*	Хугацаа		Хугацаа сунгасан огноо	Дүн		Өөрийн хөрөнгөд эзлэх хувь
										гаргасан	төлөгдөх		төгрөг	Валют	
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14	15	
	БҮГД														
	БҮГД														
	БҮГД														

**ТАЙЛАНГ ҮНЭН ЗӨВ ГАРГАСАН:**

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ  
ЕРӨНХИЙ НЯ-БО  
ЭДИЙН ЗАСАГЧ

НЭР  
НЭР  
НЭР

"Банк бус санхүүгийн байгууллагын үйл ажиллагааны зохицой харьцааны шалгуур үзүүлэлтийг тооцож, хяналт тавих журам"-ын хавсралт 8

## ГАДААД ВАЛЮТЫН ЭРСДЭЛИЙН ТАЙЛАН

ББСБ-ЫН НЭР

БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГА

/мянган  
төгрөгөөр/

20 оны ...-р улирал

	ҮЗҮҮЛЭЛТ	Валютын төрөл /тухайн валютаар/									НИЙТ ДҮН	
		USD	EUR	JPY	CHF	GBP	CN Y	RUB	KR W	Бусад	Ам.доллараар	Төгрөгөөр
A	АКТИВ											
1	Бэлэн валют											
2	Банк, санхүүгийн байгууллага дахь гадаад валютын харилцах, хадгаламжийн данс											
3	Валютаар олгосон зээлийн өрийн үлдэгдэл											
4	Санхүүгийн түрээс /валютаар/											
5	Факторингийн авлага /валютаар/											
6	Бусад											
	ДҮН											
B	ПАССИВ											
1	Итгэлцлийн үйлчилгээний өглөг											
2	Банк, санхүүгийн байгууллагаас авсан зээл											
3	Төслийн зээлийн санхүүжилт											
4	Өрийн бичиг											
5	Бусад гадаад эх үүсвэр											
6	Бусад өр төлбөр											
	ДҮН											

B	Тэнцлийн гадуурх дансдын улдэгдэл									
1	Төлбөрийн баталгаанууд									
2	Бусад хүлээж болзошгүй үүргүүд									
Г	ВАЛЮТЫН ДАНСНЫ ЦЭВЭР ЗӨРYY (I+II) I. Тэнцлийн дансуудаар (А-Б) II. Тэнцлийн гадуурх дансуудаар (В)									
Д	ВАЛЮТЫН ДАНСНЫ ЦЭВЭР ЗӨРYY (тухайн валютаар)									
Е	ӨӨРИЙН ХӨРӨНГӨ (тухайн валютаар)									
Ж	ВАЛЮТЫН ДАНСНЫ ЦЭВЭР ЗӨРYY/ӨХ*100									
З	БАЙВАЛ ЗОХИХ ХУВЬ	+/- 40%	+/- 40%	+/- 40%	+/- 40%	+/- 40%	+/- 40%	+/- 40%	+/-40%	+/-40%
	Монголбанкнаас зарласан албан ханш									

ТАЙЛАНГ ҮНЭН ЗӨВ ГАРГАСАН:

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ  
ЕРӨНХИЙ НЯ-БО  
ЭДИЙН ЗАСАГЧ

НЭР  
НЭР  
НЭР

"Банк бус санхүүгийн байгууллагын үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тооцож, хяналт тавих журам"-ын хавсралт 9

## ИТГЭЛЦЛИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ӨГЛӨГ, ӨӨРИЙН ХӨРӨНГИЙН ЗОХИСТОЙ ХАРЬЦААНЫ ТАЙЛАН

ББСБ-ЫН НЭР

БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГА

*20 оны ...-р*

улирал

*/мянган төгрөгөөр/*

ҮЗҮҮЛЭЛТҮҮД		ДҮН	
A	ХУВЬЦААТ КАПИТАЛ		
1	Ердийн хувьцаа		
2	Давуу эрхтэй хувьцаа		
3	Халаасны хувьцаа		
B	ИТГЭЛЦЛИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ӨГЛӨГ		
1	Итгэлцлийн үйлчилгээний өглөг		
B	ИТГЭЛЦЛИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ӨГЛӨГ, ӨӨРИЙН ХӨРӨНГИЙН ХАРЬЦАА (Б/А*80%)	****	
G	БАЙВАЛ ЗОХИХ / 80 ХУВИАС ИХГҮЙ/	****	80.00%
D	ХАРЬЦААНЫ БИЕЛЭГДЭЭГҮЙ ХУВЬ /Г-В/	****	
E	ШААРДЛАГАТАЙ НЭМЭЛТ ӨӨРИЙН ХӨРӨНГӨ (Б*0,8-А)	****	

ТАЙЛАНГ ҮНЭН ЗӨВ ГАРГАСАН:

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ:

НЭР

ЕРӨНХИЙ НЯ-БО:

НЭР

ЭДИЙН ЗАСАГЧ:

НЭР

"Банк бус санхүүгийн байгууллагын үйл ажиллагааны зохицой харьцааны шалгуур үзүүлэлтийг тооцож, хяналт тавих журам"-ын хавсралт 10

## ИТГЭЛЦЛИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨВЛӨРЛИЙН ТАЙЛАН

ББСБ-ЫН

БАНК БУС САНХҮҮГИЙН  
БАЙГУУЛАГА

*20 оны ...-р улирал*

*/мянган төгрөгөөр/*

Дд	Итгэмжлэгчийн овог нэр	Итгэлцлийн үйлчилгээний өглөгийн дүн	Хугацаа	Эхэлсэн огноо	Төлөгдөх огноо	Хугацаа сунгасан огноо	Итгэлцлийн үйлчилгээний өглөгийн үлдэгдэл	Хувьцаат капиталд эзлэх хувь
1								
2								
3								
4								
5								
6								
7								
8								
9								
10								
11								
12								
13								
14								
15								
16								
17								
18								
19								
20								

	БҮГД								
--	------	--	--	--	--	--	--	--	--

## Хамгийн том итгэмжлэгч

## ТАЙЛАНГ ҮНЭН ЗӨВ ГАРГАСАН:

## ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

НЭР

ЕРӨНХИЙ НЯ-БО

НЭР

ЭДИЙН ЗАСАГЧ

HEP

"Банк бус санхүүгийн байгууллагын үйл ажиллагааны зохистой харьцааны шалгuur үзүүлэлтийг тооцож, хяналт тавих журам"-ын хавсралт 11

## ҮНДСЭН ХӨРӨНГӨ, НИЙТ АКТИВЫН ЗОХИСТОЙ ХАРЬЦААНЫ ТАЙЛАН

ББСБ-ЫН НЭР

БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГА

*20 оны ...-р улирал*

*/мянган төгрөгөөр/*

ҮЗҮҮЛЭЛТҮҮД		ДҮН	
A	НИЙТ АКТИВ		
1	Нийт актив		
B	ҮНДСЭН ХӨРӨНГӨ		
2	Үндсэн хөрөнгө* /цэвэршүүлсэн/		
B	ҮНДСЭН ХӨРӨНГӨ, НИЙТ АКТИВЫН ХАРЬЦАА (Б/А*100%)	*****	
Г	БАЙВАЛ ЗОХИХ /15 ХУВИАС ИХГҮЙ/	*****	15.00%
Д	ХАРЬЦААНЫ БИЕЛЭГДЭЭГҮЙ ХУВЬ /Г-В/	*****	
E	ШААРДЛАГАТАЙ НЭМЭЛТ ЭХ YYCBЭР (A*0,15-Б)	*****	

\* зөвхөн үл хөдлөх хөрөнгө болон дуусаагүй барилгын санхүүжилт орно

## ТАЙЛАНГ ҮНЭН ЗӨВ ГАРГАСАН:

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

НЭР

ЕРӨНХИЙ НЯ-БО  
ЭДИЙН ЗАСАГЧ

НЭР  
НЭР

"Банк бус санхүүгийн байгууллагын үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тооцож, хяналт тавих журам"-ын хавсралт 12

## ЦАХИМ ТӨЛБӨР ТООЦОО, МӨНГӨН ГҮЙВУУЛГЫН ТАЙЛАН

БАНК БУС  
САНХҮҮГИЙН  
ББСБ-ЫН НЭР

БАНК БУС  
САНХҮҮГИЙН  
БАЙГУУЛЛАГА

20 оны ...-р улирал

/мянган төгрөгөөр\*/

Д/ д	Үйлчилгээни й төрөл	Цахим төлбөр тооцоо, мөнгөн гүйвуулгын үйлчилгээ /өмнөх сараар/						Цахим төлбөр тооцоо, мөнгөн гүйвуулгын үйлчилгээ/тайлан түеэр/						Өөрчлөлтүүд					
		Шилжүүлсэн			Хүлээн авч олгосон			Шилжүүлсэн			Хүлээн авч олгосон			Шилжүүлсэн			Хүлээн авч олгосон		
		Мөнг өн дүн	то о	Хув ь	Мөнг өн дүн	то о	Хув ь	Мөнг өн дүн	то о	Хув ь	Мөнг өн дүн	то о	Хув ь	Мөнг өн дүн	то о	Хув ь	Мөнг өн дүн	то о	Хув ь
1	Цахим төлбөр тооцоо, мөнгөн гүйвуулгын үйлчилгээ																		
	АНУ-ын доллар USD																		
	Евро EUR																		
	Японы иен JPY																		
	Английн фунт GBP																		
	БНХАУ-ын юань CNY																		

	ОХУ-ЫН рубль RUB												
	Бусад валют												

ТАЙЛАНГ ҮНЭН ЗӨВ ГАРГАСАН:

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ  
ЕРӨНХИЙ НЯ-БО  
ЭДИЙН ЗАСАГЧ

НЭР  
НЭР  
НЭР

"Банк бус санхүүгийн байгууллагын үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тооцож, хяналт тавих журам"-ын хавсралт 13

**ХААЛТТАЙ ӨРИЙН БИЧИГ, ӨӨРИЙН ХӨРӨНГИЙН  
ЗОХИСТОЙ ХАРЬЦААНЫ ТАЙЛАН**

ББСБ-ЫН НЭР

БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГА

*20 оны ...-р*

*улирал*

*/мянган төгрөгөөр/*

	ҮЗҮҮЛЭЛТҮҮД	ДҮН	
A	Хаалттай өрийн бичиг		
Б	ХААЛТТАЙ ӨРИЙН БИЧИГ, ӨӨРИЙН ХӨРӨНГИЙН ХАРЬЦАА (Б/А*50%)	****	
В	БАЙВАЛ ЗОХИХ / 50 ХУВИАС ИХГҮЙ/	****	50.00%
Г	ХАРЬЦААНЫ БИЕЛЭГДЭЭГҮЙ ХУВЬ /Г-В/	****	

ТАЙЛАНГ ҮНЭН ЗӨВ ГАРГАСАН:  
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ:

НЭР

ЕРӨНХИЙ НЯ-БО:

НЭР

ЭДИЙН ЗАСАГЧ:

НЭР

"Банк бус санхүүгийн байгууллагын үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тооцож, хяналт тавих журам"-ын хавсралт 14

ВАЛЮТЫН АРИЛЖААНЫ МЭДЭЭ  
/долоо хоногоор/

.....сарын.....өдрөөс .....сарын .....өдрийн валютын арилжааны мэдээ  
/компанийн нэр/

Д/д	Өдөр	Иргэд, хуулийн этгээдийн аль нь болох	Валют /тус бүрээр/	Ханш	ДҮН		Зориулалт
					авсан	зарсан	

Мэдээ гаргасан ажилтны албан тушаал .....

Овог нэр .....

Гарын үсэг.....

/тамга/

"Банк бус санхүүгийн байгууллагын үйл ажиллагааны зохицой харьцааны шалгуур үзүүлэлтийг тооцож, хяналт тавих журам"-ын хавсралт 15

**ГАДААД ВАЛЮТЫН АРИЛЖААНЫ МЭДЭЭ**  
**/сараар/**

20... оны ...-р сарын ... өдөр

ББСБ-ын нэр:					Утас:	Факс:
№	Худалдаж авсан	Валютын төрөл / <i>тус бүрээр/</i>	Ханш	Валютын дүн	Америк долларт хөрвүүлснээр	Төгрөгөөр
1	Хуулийн этгээдээс					
2	Иргэээс					
	ДҮН					
	Дундаж ханш					
№	Худалдсан	Валютын төрөл / <i>тус бүрээр/</i>	Ханш	Валютын дүн	Америк долларт хөрвүүлснээр	Төгрөгөөр
1	Хуулийн этгээдэд					
2	Иргэнд					
	ДҮН					
	Дундаж ханш					

Мэдээ гаргасан ажилтны албан тушаал .....

Овог нэр .....

Гарын үсэг.....

*/тамга/*

-- ooOoo --